

№	Он, сар, өдөр, цаг, минут	Бүртгэлийн дугаар	Утга	Төрөл	Биелэлт
2021 он					
1	2021.01.05	0000017038	Өмнөговь аймгийн Гашуунсухайт боомт дээр PCR шинжилгээ өгөөгүй, хулгайн замаар явж ирсэн маш олон жолооч байна. Өвчин тараах эрсдэлтэй байгаа тул яаралтай арга хэмжээ авч, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Өмнөговь аймаг дахь цагдаагийн газраас "Хулгайн тээвэр" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд шалгалтын ажиллагаа явуулахад батлагдаагүй тул энэ тухай гомдол гаргагч иргэн Д.Ганболдод хариу мэдэгдсэн болно.
2	2021.01.07	0000017298	2020 оны 1-р сарын 4-ний өдөр жолоодох эрхээ хасуулаад Төрийн банкны дансанд 400,000₮ шилжүүлсэн боловч торгууль төлөгдөөгүй төлөвт байна. Шалгаад хасалт хийж өгнө үү. Торгуулийн дугаар: 3100006200011874	Хүсэлт /веб хуудас/	Иргэн Ж.Баярсайханы 2020 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр төлсөн 3100006200011874 дугаартай торгууль нь torguuli.police.gov.mn сайтад торгууль төлсөн өдөр буюу 2020 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр "төлөгдсөн" төлөвт орсон байна. Энэ талаар иргэнд хариу мэдэгдсэн болно.
3	2021.01.12	000018334	Гомдол №0000004086 "Говь-алтай аймагт 5-р сард хүү маань хурд хэтрүүлж явсан машинд дайруулж нас барсан юм. Аймгийн цагдаагийн хэлтсээс ажлын хэсэг ирсэн. Автын ослын дүгнэлт гараагүй байна гээд одоог хүртэл тодорхой хариу өгөхгүй байна. Хүүг маань дайрсан жолооч одоог хүртэл сул чөлөөтэй жолоо бариад явж байна. Наадмаар сумын цагдаатай хамт явж байсан. Энэ талаар 7-р сарын 24-ний өдөр 1111-ээр дамжуулж Цагдаагийн ерөнхий газарт гомдол гаргасан юм. Гэтэл одоог хүртэл арга хэмжээ авахгүй хариу өгөхгүй байна. Говь-алтай аймгийн Цагдаагийн хэлтэс болон бусад хууль хяналтын байгууллагууд нэг талыг барьж, хүнд суртал гаргаж одоог хүртэл шийдвэрлэхгүй байна. Хүүг маань дайрсан хүн жолоо бариад явж байна. Яаралтай арга хэмжээ авч, асуудлыг шийдвэрлэж өгнө үү." талаар гомдол гаргасан юм. Цагдаагийн ерөнхий газраас "Иргэний гомдлын дагуу Говь-Алтай аймаг дахь цагдаагийн газраас шалгалтын	Гомдол /дуудлага/	Иргэний гомдолд Говь-алтай аймаг дахь цагдаагийн газар шинжээч нараас мэдүүлэг авах, прокурорын даалгаварт заагдсан ажиллагаа явуулж байгаа бөгөөд энэ талаар иргэн Д.Цолмонд 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 32/134 дугаар албан бичгээр хариу мэдэгдсэн болно.

			ажиллагаа явуулж, хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар хариу мэдэгдсэн болно.\\" гэсэн хариу өгсөн. Гэтэл Говь-алтай аймгийн цагдаагийн газраас таний хэргийг хаана гэх юм. Маш их гомдолтой байна. Яаралтай арга хэмжээ авч хариу мэдэгдэнэ үү.		
4	2021.01.19	0000019253	Миний бие жолооны үнэмлэхийн хугацаа дууссан тул 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр жолооны үнэмлэх захиалсан. Мөн оны 12 дугаар сарын 22-ны өдөр "emongolia" чатаар холбогдоход "торгууль төлөөгүй шалтгаанаар татгалзсан байна. 70191319 дугаарт залгаж хасалтаа хийлгээрэй" гэсэн. Энэ дугаар дуудлага хүлээж авахгүй байсан тул 95981152 дугаарын утсаар холбогдож асуухад татгалзах шалтгаан байхгүй байна гэсэн. Дараа нь 94060600 дугаараас холбогдож "Уучлаарай таны үнэмлэх гарсан. Бид андуурсан байна" гэж хэлсэн. Би үнэмлэх захиалаад өнөөдрийг хүртэл ямар ч мэдээлэлгүй, чатаар болон комментоор лавлахад хариулт өгдөггүй. Бусад иргэдийн жолооны үнэмлэх 7-8 хоногт гэрийн хаягаар хүргэгдсэн байна. Энэ ялгаварлал уу, эсвэл хэвлэлттэй холбоотой алдаа дутагдал гарсаныг нуун дарагдуулж байгаа юу. Үнэхээр гомдолтой байна. Надтай нэн даруй холбогдож, тээврийн хэрэгслээ жолоодох, зорчих эрхийг хангаж өгөх, ялгаварлан гадуурхаж, чирэгдүүлсэн алба хаагчдад хариуцлага тооцож, хариу мэдэгдэхийг хүсье.	Гомдол /веб сайт/	Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвөөс иргэнд хариу мэдэгдсэн болно.
5	2021.01.20	0000019799	Ээж маань 2020 оны 10 дугаар сарын 16-ны өдөр бурхан болсон. Буян компанид дуудлага өгөөд ирж амжаагүй байхад хаанаас ирж байгаа нь тодорхойгүй хүмүүс ирж, цогцсыг авч явахыг оролдож, зүй бус үйлдэл гаргасан. Машин нь УБЦ 46-28 улсын дугаартай, хажуудаа 88103103 утасны дугаар бичсэн эмнэлгийн машин байсан. Яаралтай шалгаж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Мөрдөн байцаах албанаас шалгалтын ажиллагаа явуулж, 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдөр иргэнд хариу мэдэгдсэн болно.
6	2021.01.23	0000020277	Миний бие 2020 оны 01 дүгээр сард жолооны үнэмлэхээ хураалгасан юм. Амьдралын эх үүсвэр болсон ажлаа хийхийн тулд танилынхаа санал болгосноор М.Батзаяа (утасны дугаар 8888-8183) гэгч цагдаагийн алба хаагчтай холбогдож, 800.000₮ шилжүүлбэл үнэмлэхийг нь сэргээгээд өгье гэсний дагуу мөн оны 01 дүгээр сарын 08-ны өдөр мөнгийг шилжүүлсэн. (Шилжүүлгийн хуулга	Гомдол /веб сайт/	Иргэний гомдлыг хүлээн авч, шалгахад М.Батзаяа нь цагдаагийн алба хаагч биш, цагдаагийн алба хаагчийн нэрийг барьж залилан мэхлэх гэмт хэргийн шинжтэй үйлдэл хийсэн байх тул Өмнөговь аймаг дахь цагдаагийн газарт шалгуулахаар шилжүүлж, энэ тухай Цагдаагийн ерөнхий газрын

			хавсаргав). Гэвч үнэмлэхийг маань сэргээж өгөөгүй бөгөөд 300.000₮ буцааж өгөөд, үлдэгдэл мөнгийг өгөхгүй байна. Авилга авч, иргэнийг луйвардсан цагдаагийн алба хаагчид хариуцлага тооцож, хохирлыг барагдуулж өгнө үү.		Аюулгүй байдлын хэлтсээс 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 838 дугаар албан бичгээр иргэн Ж.Баярсайханд хариу мэдэгдсэн болно.
7	2021.01.25	0000020337	Toyota Land Cruiser 100 маркийн /хар өнгийн/ 85-87 УНН улсын дугаартай энгийн автомашин тусгай дуут дохио хэрэглэж, замын хөдөлгөөнд оролцож байна. Яаралтай шалгаж, арга хэмжээ авна уу.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Тээврийн цагдаагийн албанаас шалгалтын ажиллагаа явуулахад 2021 оны 02 дугаар сарын 12-ны өдөр Баянзүрх дүүрэгт оршин суух иргэн Э нь хуулиар хориглосон тусгай дуут болон гэрлэн дохио суурилуулсан тээврийн хэрэгсэл жолоодож, замын хөдөлгөөнд оролцсон тул ЗТХ-ийн 14.7.16-д зааснаар 100.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан болно
8	2021.01.25	0000020565	2021 оны 01 дүгээр сарын 17-ны шөнө төөрсөн хүүхдийг минь олж өгсөн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн алба хаагч, цагдаагийн дэслэгч Мөнгөншагай, дэд ахлагч Мөнгөнбагана нарт талархал илэрхийлье. Төрийн албаа нэр төртэй гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчдад ажлын амжилт хүсэн ерөөе.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
9	2021.02.01	0000021395	Экологийн цагдаагийн албанд ажилладаг нөхөр маань зунаас хойш нэг ч өдөр гэртээ байсангүй. Би саяхан амаржсан, 14 хоног хэвтрийн дэглэмтэй 3 нялх хүүхэдтэйгээ байна. Гэтэл манай нөхрийг тусгаарлалтад байгаа өвчтэй хүмүүсийн хамгаалалтад явуулчихсан. Учраа хэлээд явахгүй байж болохгүй юм уу гэхээр явахгүй байж болохгүй гээд явсан. Удирдах албан тушаалтан нь алба хаагчдынхаа ар гэр, ахуй амьдралыг нь бодолцдоггүй юм уу. Холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.	Санал, хүсэлт /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Экологийн цагдаагийн албаны Урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Г.Арсланхуяг иргэнтэй утсаар холбогдож, хариу тайлбар өгсөн болно.
10	2021.02.01	0000020987	2019 оны 12 дугаар сард жолоодох эрхээ хасуулаад сургалтандаа суугаад, бичиг баримтаа бүрдүүлээд оны 1 дүгээр сард эрх сэргээх хүсэлтээ өгсөн боловч одоо болтол шийдвэрлээгүй байна. Ажил төрөл хийж гэр бүлээ тэжээмээр байна. Асуудлыг яаралтай шийдэж өгнө үү. Маш их бухимдалтай байна.	Гомдол /веб хуудас/	Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл, хяналтын төвөөс 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдөр иргэн Ч.Батзаяад хариу мэдэгдсэн болно.

11	2021.02.10	0000022246	2020 оны 5 дугаар сарын 12-ны өдөр "Наранзолбоот" кашмер ХХК-д ноолуур нийлүүлээд одоог хүртэл мөнгөө авч чадахгүй байна. Энэ талаар аймгийн цагдаагийн газарт гомдол гаргасан боловч, арга хэмжээ авахгүй 1 жил болж байна. Арга хэмжээ авч өгнө үү.	Санал хүсэлт /дуудлага/	Дундговь аймаг дахь цагдаагийн газраас иргэн П.Амгаланбаатартай холбогдож, асуудлыг тодруулахад "хуулийн байгууллагааг шийдвэрлүүлж байгаа, Прокурорын байгууллагаас хариу хүлээн авсан тул гомдол, саналгүй" гэсэн болно.
12	2021.02.16	0000023221	Цахим ертөнцөд н.Осоржаамаа, эмгэн 2 ямар ч хараа хяналт байхгүй, хувцасаа тайчиж, зүй бус үйлдэл их гаргаж байна. Энэ нь хүүхдийн хүмүүжилд сөргөөр нөлөөлөхөөр байгаа тул арга хэмжээ авна уу.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдол мэдээллийг шалгаад Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 10/1534 дүгээр албан бичгээр иргэн Б.Доржид хариу мэдэгдсэн.
13	2021.02.15	0000023071	Сэлэнгэ аймаг дахь цагдаагийн газар нь УИХ-ын гишүүн Чойжилсүрэнгийн "Хурд авто" ХХК-тай холбоотой хэргийг шалгахгүй нуун дарагдуулсан. Одоо АТГ-ын мөрдөн байцаагчийн мэдэгдлийг хуурамчаар үйлдсэн хэргийг дараад шалгахгүй байна. Шалгаж арга хэмжээ авч өгнө үү.	Санал хүсэлт /дуудлага/	Мөрдөн байцаах албанаас 2021 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 12/1-1252 дугаар албан бичгээр иргэн Д.Батбаатарт хариу өгсөн.
14	2021.02.24	0000024044	Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын алба хаагч н.Марал-Эрдэнэ нь надтай ёс зүйгүй харьцаж, айлган сүрдүүлсэнд гомдолтой байна. Яаралтай арга хэмжээ авч, хариуцлага тооцно уу.	Гомдол /дуудлага /	Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газрын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 17а/527 дугаар албан бичгээр иргэн Б.Нинжинд хариу мэдэгдсэн болно.
15	2021.03.01	0000024233	Зогсоолд тавьсан машины гэрлийг хагалсан этгээдийг илрүүлж, хохиролгүй болгож өгсөн Мэдээлэл, дүн шинжилгээ, шуурхай удирдлагын албаны Шуурхай удирдлагын төвийн цагдаа н.Бат-Эрдэнэд талархсанаа илэрхийлж, цаашдынх нь ажилд өндөр амжилт хүсье.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
16	2021.03.02	0000025201	Цагдаагийн албан хаагчид эзэнгүй хулгайн хэргээ илрүүлэхийн оронд "Зөрчлийн хууль"-ийг урдаа барьж хүнсний дэлгүүрүүдийг ихээр оролдож, шантаажилж, дотоод үйл ажиллагаанд нь оролцож байна. Чиг үүргийнхээ дагуу ажиллах ёстой цагдаагийн байгууллага нь мэргэжлийн хяналтын ажлыг хийгээд яваад байна. Холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч, хариу өгнө үү.	Шүүмжлэл /веб сайт/	Нийслэлийн цагдаагийн удирдах газраас иргэн Г.Энхбаярт хариу мэдэгдсэн болно.

17	2021.03.03	0000025855	Цагдаагийн байгууллагад уламжилж өгнө үү. Манай хүү Налайх дүүргийн цагдаагийн хэлтэст ажилладаг юм. 5 жилийн өмнө Амгаланд цагдаагийн байр баригдана гээд урьдчилгаа 14,0 сая төгрөг өгсөн юм. Гэтэл одоог хүртэл мөнгөө ав чадахгүй байна. Барилгын компани болон цагдаагийн газрын хүмүүс мөнгө идсэн хэргээр шүүхээр явж байгаа юм байна лээ. Энэ асуудлыг шийдэж өгнө үү. Иргэнд хариу өгнө үү.	Санал /дуудлага/	Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас 2021 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн 6/367 дугаар албан бичгээр иргэн С.Энхтуяад хариу хүргүүлсэн болно.
18	2021.03.09	000026660	Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн ахлах дэслэгч Г.Чингис-д баярласан талархсанаа илэрхийлье.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
19	2021.03.11	000027769	Улаанбаатар төмөр замын Цагдаагийн албаны цагдаа н.Улсбаяр /хувийн дугаар 721742/, н.Эрдэнэсайхан /хувийн дугаар 32683/ нар Дархан-Улаанбаатар чиглэлийн 281 дүгээр галт тэрэгний 5 дугаар вагонд 2019-9-29-ний өдөр анхны тусламж үзүүлж хүний амь аварсан. Мөн тус албаны цагдаа С.Мөнх-Эрдэнэ /хувийн дугаар 319117/ Улаанбаатар-Зүүнхараа чиглэлийн 281 дүгээр галт тэрэг 5 дугаар вагонд зорчигчийн хаясан утсыг 1 жилийн дараа эзэнд нь олж өгсөн. Иймд дээрх цагдаагийн албан хаагчдад ар гэрийн зүгээс баярласан талархсанаа тус тус илэрхийлж байна.	Талархал /дуудлага/	Талархлыг Тээврийн цагдаагийн албанд хүргүүлэв
20	2021.03.12	0000027769	2019 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Дархан-Улаанбаатар чиглэлийн 281 дүгээр галт тэрэгний 5 дугаар вагонд анхны тусламж үзүүлж хүний амь аварсан Төмөр замын цагдаагийн газрын цагдаа н.Улсбаяр /хувийн дугаар 721742/, н.Эрдэнэсайхан /хувийн дугаар 32683/, Улаанбаатар-Зүүнхараа чиглэлийн 281 дүгээр галт тэргэнд зорчигчийн гээгдүүлсэн утсыг олж өгсөн мөн газрын цагдаа С.Мөнх-Эрдэнэ /хувийн дугаар 319117/ нарт баярласан талархсанаа илэрхийлье. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Талархал /дуудлага/	Талархлыг Тээврийн цагдаагийн албанд хүргүүлэв.

21	2021.03.12	0000027460	2020 оны 10 дугаар сарын 23-ны өдөр Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газрын 2 дугаар хэлтэст гомдол гаргахад шалгаж, шийдвэрлэхгүй байгаад гомдолтой байна. Яаралтай шалгаж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн газраас иргэнд хариу мэдэгдсэн болно.
22	2021.03.19	0000024427	Гаалиас шинээр буусан машиныг 72 цагийн дотор оруулдаг байсныг болиулсан байна. Шууд ачиж тээвэрлэх ёстой гэсэн журам гарсан гэнэ. Бид гаалиас машинаа буулгаж авлаа гэхэд гааль дээр оношилгооны газар байхгүй, гэтэл оношилгооны газар очиж оношилгоонд оруулах ёстой. Замын хөдөлгөөнд ороод явахаар замын цагдаа нар шууд журмын хашаанд оруулна явуулахгүй гээд байх юм. Энэ асуудлыг холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Гомдол /дуудлага/	Тээврийн цагдаагийн албанаас 2021 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 15 цагт иргэнтэй утсаар холбогдож, хариу мэдэгдсэн болно.
23	2021.03.25	0000030337	Миний бие 2020 оны 9 дүгээр сард pruis-30 маркийн авто машинаа бусдад залилуулсан талаар өргөдөл гомдол гаргахад Баянгол дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтсийн мөрдөгч н.Энхмаа шалгаж, шийдвэрлэж өгөхгүй байсан тул байцаагчаа солих хүсэлт гаргасан юм. Одоо Амгаланбаатар байцаагч дээр миний өргөдөл очсон бөгөөд асуухаар танилцаагүй байна гэх юм. Банк санхүүгийн байгууллагаас машиныг чинь хурааж авна гээд байна. Миний бие хараагүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн юм. Энэ асуудлыг яаралтай шалгаж, шийдвэрлэж өгнө үү.	Гомдол /дуудлага/	Мөрдөн байцаах албанаас иргэнд хариу мэдэгдсэн болно.
24	2021.03.25	0000030706	Хулгай хийгээд, хүн гүтгэж, эрх чөлөөнд халдаад байгаа этгээдийг Завхан аймгийн Шүүх, прокурор, цагдаагийн газар арга хэмжээ авахгүй байгаад гомдолтой байна. Нэг хулгайч шүүгч, прокурорыг орлоод намайг гүтгээд данс хаалгаад, ирж зодоод байхад цагдаагийн байгууллага нь шалгаж өгөхгүй байна шүү дээ. Энэ ямар учиртай юм бэ? Холбогдох газарт нь уламжилж арга хэмжээ авч өгнө үү.	Гомдол /дуудлага/	Завхан аймаг дахь цагдаагийн газраас иргэнд хариу мэдэгдсэн болно.

25	2021.03.31	0000032625	Дорноговь аймгийн Засаг даргын захирамжаар цар тахалтай холбогдуулан орой 20.00 цагаас хойш хөдөлгөөн хорьж байгаа юм. Би ажлаа тараад 20 цаг 20 минутад алхаж явахад цагдаа зогсоогоод иргэний үнэмлэхээ шалгуулаад явах гэсэн цагдаагийн хошууч Даваахүү бичиг баримтаа өг гэхээр нь бичиг баримтаа шалгуулсан шүү дээ гэж хэлсэн. Гэтэл чамайг шалгана, машинд суу гээд ёс зүйгүй харьцсан. Цагдаагийн алба хаагчийн өөдөөс их юм ярьлаа, Зөрчлийн хуулиар тултал нь торго гэсэн. Иймд Дорноговь аймаг дахь цагдаагийн газрын дэд дарга Даваахүүд гомдолтой байна. Шалгаж, арга хэмжээ авч өгнө үү.	Гомдол /дуудлага/	Дорноговь аймаг дахь цагдаагийн газраас шалгалтын ажиллагаа явуулахад цагдаагийн алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй тул энэ талаар иргэнд хариу мэдэгдсэн.
26	2021.04.02	0000032834	Би Цагдаагийн ерөнхий газрын Хангалт үйлчилгээний төвд слесариар ажиллаж байхад 2020 оны 8 дугаар сард Баярсайхан дарга дуудаад слесарийн орон тоогүй болж байгаа гээд ажлаас халсан. Манайх олон хүүхэдтэй, эхнэр хагалгаанд орсон ажилгүй хэцүү байна. Ямар учраас ажлаас халсан бэ. Холбогдох газарт уламжилж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдолд Цагдаагийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн албанаас хариу мэдэгдсэн болно.
27	2021.04.05	0000033622	2016 онд Галт зэвсэг эзэмших эрх олгох сургалтад суугаад гэрчилгээ авсан боловч “бүртгэлд мэдээлэл ороогүй байна. Архиваас шүүлгэ” гэх юм. Асуудлыг холбогдох газарт нь уламжилж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Цагдаагийн ерөнхий газрын Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвөөс иргэн Б.Бат-Эрдэнэд гэрчилгээг нөхөн олгож, галт зэвсгийн нэгдсэн санд бүртгэсэн болно.
28	2021.04.07	0000034431	2017 оны 12 дугаар сарын 26-ны өдөр торгуулиа төлсөн боловч мэдээллийн сангаас хасагдахгүй байна. Жолоодох эрхийн хүчинтэй хугацаа дуусаад дахин захиалах гэхээр торгууль төлөгдсөний дараа хугацаа сунгах захиалгыг хүлээж авах боломжтой гэсэн хариу ирж байгаа тул мэдээллийн санд хасалт хийж өгнө үү. Торгууль төлсөн баримтыг хавсаргав.	Хүсэлт /И-мэйл/	Тээврийн цагдаагийн албанаас иргэний торгууль төлсөн баримтын хуулбарыг бүртгэлд авч, торгуулийг төлөгдсөн төлөвт оруулахаар холбогдох албанд хүргүүлж, энэ талаар иргэн Ч.Энхбатад хариу мэдэгдсэн болно.
29	2021.04.12	0000035461	Хөл хорионы үеэр гэрийнхээ ойролцоо 200м дотор хүүхдээ салхилуулах гэхэд танай хэнхэг цагдаа нар явуулахгүй өвчигнөх юм. Энэ цагдаа нарынхаа хандлага боловсролд анхаараачээ. Ялгаварлан үзэх үзэлтэй, хүний эрхийн ямар ч ойлголтгүй тийм бүдүүлэг юмнуудаа Улсын онцгой комисс, Нийслэлийн онцгой комиссын шийдвэрийн хүрээнд ажилла гэж хэлмээр байна. Улсын онцгой комисс,	Гомдол /вэб хуудас/	Иргэний гомдлыг хүлээн авч, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас хариу мэдэгдсэн болно.

			<p>Нисйлэлийн онцгой комиссийн шийдвэрийг дураарай ингэж муйхарлаж зохиож өөрийн үзэмжээр хандаж болдог юм уу?</p> <p>Явган хүний замаар гэрийнхээ ойролцоо ч явж чадахгүй байна. Ялтантай харьцаж бгаа мэт харилцдаг, хашиж боохоо л түрүүнд тавьдаг болохоор танай цагдаагийн албаны нэр хүнд үнэндээ гутамшиг боллоо. Хэдэн шоронгийн хуяг авчраад тавьцымуу хаашаа юм. Танай тээврийн цагдаагийн алба яахлаараа ингэж хөл хөөрцөг болж машин хорьж сүржигнэдэг юм? Одоо жаахан цахимжаачээ эргүүтээд хэдэн боловсролгүй бүдүүлэг хуучинсаг хандлагатай юмнуудаа замдээр өдөржин зогсоогоов нөгөөдүүл нь тэрэндээ эрдсэн, хавийн амьтныг хоригдол оргодол босуул шиг хандаж хүний эрхийг өдрийн турш зөрчиж, худлаа Зөрчлийн хууль ярьсан шиг. Наад цагдаа нартаа зөрчлийн хуулиа хэзээ ярихвээ гэдгээ зааж өгөөч? Өөрөө дур мэдэн дүрэм зохиочоод тэрийг нь зөрвөл зөрчлийн хууль ярьж ард иргэдийг дарамтлах юм, бүр кайфтай нь аргагүй, донтой, зэрлэг балмад нь хүртэл мэдэгдэхүйц. Цахтм махимаа ашиглаад тэр хэдэн юмнуудаа амрааж сургалт нтрт суулгаж хандлага сэтгэхүйг нь өөрчлөөч!</p>		
30	2021.04.12	0000038573	<p>Төв аймгийн Баянжаргалан суманд Дэлгэрхангай уурхайд манаачаар ажиллаж байсан гэр бүлийн тухай би гомдол мэдүүлсэн юм. Хүчирхийлэлийн төвд хандсан, 107 утсанд мэдэгдсэн. Хохирогч эмэгтэй нь ээжийнх нь төрсөн дүү нагац эгч бие муутай уншиж мэдэхгүй хонь хариулдаг, өмссөн хувцас нь ноорхой хоол хүнс өгдөггүй бид нар хонинд явж байхад нь нуугдаж байж хоол хүнс өгдөг. "...Нөхөр нь намайг машинаар дайрч алаад уурхайн нүхэнд булна гэсэн би айж байна гэж байсан. Хоёр жил энэ айлд зарцлагдахдаа хүүтэйгээ уулзаагүй" гэж ярьж байсан. Төв аймгийн цагдаагийн газарт хандаад хоёр хүнийг авч яваад байцаасан, гэтэл орой нь буцаагаад явуулчихсан байсан. Хот руу явуулья гэхээр цар тахалтай гээд явуулаагүй гэж байна. Групп авдаг юм шиг байна энэ эмэгтэйд ямар ч мөнгө өгдөггүй, өглөөнөөс орой хүртэл мал маллаж байна, гар нь цоорчихсон мах нь гарчихсан</p>	Гомдол /дуудлага/	Төв аймаг дахь цагдаагийн газраас иргэнд хариу мэдэгдсэн болно.

			байхад энэ хэд намайг эмнэлэгт үзүүлдэггүй гэж ярьж байх юм. Төв аймгийн цагдаагийн газарт хандаад арга хэмжээ авахгүй байна. Үүнийг цааш нь холбогдох газарт нь уламжилж яаралтай арга хэмжээ авч өгнө үү.		
31	2021.04.29	0000040957	Пабжи, дота компьютерын тоглоомыг хүүхдүүдэд тоглуулахгүй байх талаар арга хэмжээ авч өгнө үү. Хүүхэд байтугай том хүнийг донтуулж байна. Хүүхдүүд утсаараа тоглоод, үүрэн холбооны газрууд дата өгч байна. Монгол улсын хэмжээнд энэ тоглоомыг хааж өгнө үү гэсэн саналтай. Хүүхдүүд сэтгэл мэдрэлийн эмнэлэгт хэвтэж байна. Холбогдох газарт нь уламжилж иргэнд тодорхой хариу өгнө үү.	Санал /дуудлага/	Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсээс иргэнд хариу хүргүүлсэн болно.
32	2021.05.13	0000046052	Дорноговь аймгийн Даланжаргалан суманд байрлах миний 50 хувийн хувьцаа эзэмшдэг нүүрсний уурхайд н.Мэргэн-Уул Д.Батзориг, Д.Ичинхорлоо нар халдсан үйлдлийг мөн аймгийн цагдаагийн газарт дуудлага өгч, мэдэгдсэн боловч таслан зогсоох арга хэмжээ авахгүй байна. Асуудлыг холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.	Гомдол /дуудлага/	Дорноговь аймаг дахь цагдаагийн газраас иргэнд хариу мэдэгдсэн болно.
33	2021.05.17	0000048710	Манай гэр бүлийн хүн цагдаагийн байгууллагад ажилладаг юм. 2020 оны 10 дугаар сараас хойш бараг амарсангүй, өглөө 7 цагт гараад орой 21-22 цагт ирдэг. Хэтэрхий ачаалалтай ажилаад, хүн юм чинь ядарч байна шүү дээ. Ямар ч амьд амьтан мал байсан ч ядрана биздээ. Цагдаагийн алба хаагчдаа ээлж дараатай амраамаар юм. Туйлдаж байна. Асуудлыг судлан үзэж, шийдвэрлэх арга хэмжээ авна уу.	Гомдол /дуудлага/	Баянзүрх дүүрэг дэх замын цагдаагийн хэлтсээс алба хаагчдын ээлжийн амралтын асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд иргэн Г.Батцэнгэлтэй холбогдоход гомдол, саналгүй гэсэн болно.
34	2021.05.17	0000046971	Орон байранд үйлдэгдсэн хулгайлах гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлсэн цагдаагийн хурандаа Э.Бат-Эрдэнэ даргатай Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтэс, эрүүгийн тасгийн хамт олонд баярласан талархсанаа илэрхийлж байна. Танай хамт олонд ажлын амжилт хүсэе.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
35	2021.05.20	0000050939	Миний бие Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт "РС молл" худалдааны төвийн 13 давхарт өлсгөлөн зарлаж байна, Гадаадын иргэнээс 36 сая төгрөг авсан байтал надаас 110 сая төгрөг болгож авна гээд байх юм. Монголд ийм хууль байхгүй шүү дээ. Шүүх, цагдаагийн байгууллагаар 2-3 жил яваад арга хэмжээ авахгүй байна.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Чингэлтэй дүүрэг дэх цагдаагийн 1-р хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, цагдаагийн хошууч Б.Дулмаадорж, ахлах байцаагч, цагдаагийн ахмад Э.Саруул нар иргэн Д.Цэцгээтэй биечлэн уулзахад уг асуудал нь Иргэний хуулийн зээлийн

			Надад цаг хугацаа байхгүй боллоо. Холбогдох газарт нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.		гэрээгээр зохицуулсан хуулийн этгээд, иргэд хоорондын эд хөрөнгийн маргааны шинжтэй асуудал байх тул холбогдох хууль, хяналтын байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, өлсгөлөн зарласан үйлдэл нь өөрийн эрүүл мэндэд аюултай талаар ойлгуулж, тус өлсгөлөнг 2021 оны 05 дугаар сарын 23-ны өдөр зогсоосон байна.
36	2021.05.21	0000050647	Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн авто замын хөдөлгөөний дүрмийг тусгай дуут дохиотой төрийн албаны тээврийн хэрэгслүүд зөрчиж байгаа тул холбогдох газар нь шалгаж, буруутай албан тушаалтанд арга хэмжээ авна уу.	Гомдол /веб хуудас/	Тээврийн цагдаагийн албанаас иргэнтэй холбогдож, хариу мэдэгдсэн болно.
37	2021.05.21	0000051977	Сайн байна уу? Дарханы Шарын голын 17 дугаар цэцэрлэгийн дуу хөгжмийн багш Баяраагийн Одгийв гэгч нь өмнө нь хамтран амьдарч байсан /2018 онд салсан/ С.Зоригт гэгчийн фэйс хаягаар нь орж хувийн чатыг олон нийтийн сүлжээнд тавьж миний нэр төрд халдаж, ганц би ч биш олон хүний нэр төрийг гутаан доромжилж байна. Мөн намайг ажлаас халуулсан. Би 3 хүүхдийн хамт 2020 оны 9 сараас эхлэн өрх толгойлон амьдарч байна. Сүүлдээ эх байх эрхийг чинь хасуулна гэж дарамталж, маш гүн сэтгэлийн хямралд оруулж байна. Хэнтий аймгийн Цагдаагийн газарт 5 сарын 5ны өдөр өргөдөл өгсөн боловч Биндэр сум руу шилжүүлсэн. Цагдаа дээр энэ хэрэг шийдэгдэхгүй байгаа учир танайд хандаж байна. 2020 оны 9 сараас эхлэн Ард даатгалын Хэнтий салбарт ажиллаж байсан боловч одоо намайг ажилгүй болгосон. Нэр хүнд болон сэтгэлийн дарамтанд оруулсан ажилгүй болгосон гэх хохирлыг нөхөн төлүүлмээр байна. С.Зоригт гэгчтэй харьцсан чат болон Одгийв гэгчийн дарамталсан мсжийг хавсралтаар хүргүүлэв. Зохих шатны байгууллагад хүргүүлж шийдвэрлэж өгнө үү.	Гомдол /веб хуудас/	Хэнтий аймаг дахь цагдаагийн газар шалгалтын ажиллагаа явуулж, иргэнд хариу мэдэгдсэн болно.

38	2021.05.31	0000053898	Миний гомдлыг Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл, шуурхай удирдлагын төвд хуваарилж өгнө үү. Энэ оны 05 дугаар сарын 20-ны өглөө 99266367 дугаараас 103 руу залгаад “бие өвдөж байгаа талаар хэлэхэд дуудлага өгөх юм уу, зөвлөгөө авах юм уу гэсэн. Зөвлөгөө авъя гэтэл 19001903 руу залга” гэхээр нь тэр дугаарт залгатал “таны нэгж хүрэхгүй байна” гэж хариулсан. Нэгжгүй бол үх гэж байгаа юм уу? Ийм тэнэг журам хэн гаргасан юм бэ? Буруутай хүнийг олж хариуцлага тооцооч ээ. 7 хоногийн дараа хариу өгөхгүй бол 103-ын ажилтны яриагаа телевизүүдээр үзээрэй.	Гомдол /веб хуудас/	Мэдээлэл шуурхай удирдлагын төвөөс иргэнтэй холбогдож, хариу мэдэгдсэн болно.
39	2021.06.02	0000055675	Өргөн замуудын явган хүний гарц дээрх гэрлэн дохионы ногоон гэрэл асах хугацааг уртасгах шаардлагатай байна. Ногоон гэрэл асахтай зэрэгцээд зам гарч байхад улаан гэрэл асаад осолд өртөх эрсдэлтэй байна. Холбогдох газарт уламжилж өгнө үү.	Гомдол /дуудлага/	Тээврийн цагдаагийн албанаас 14-1в/220 дугаар албан бичгээр иргэн В.Баасансүрэнд хариу мэдэгдсэн болно.
40	2021.06.04	0000056539	Нийгмийн даатгалын ерөнхий газраас таны мэдээллийг авсан гээд 70123225 дугаараас залгаад миний бүх мэдээллийг хэлээд таныг урамшуулах гэж байгаа манай дансанд 200.000 төгрөг шилжүүл гэх юм. Хаанаас ярьж байгаа юм гэж асуухаар төрийн бус байгууллагаас гээд ямар нэртэйгээ ч хэлэхгүй байна. Миний ойрын хүмүүс рүү мөн тэгж ярьсан байна. Яаралтай шалгаж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Мөрдөн байцаах албанаас шалгалтын ажиллагаа явуулж, иргэнд хариу мэдэгдсэн болно.
41	2021.06.10	0000058366	Хятад улсын Хөрөнгө оруулагч иргэн Монгол улсад хууль бус химийн бодис оруулж ирж зарж байгаа талаар энэ оны 03 дугаар сарын 10-ны өдөр Экологийн цагдаагийн албанд гомдол гаргасан. Гэвч энэ хэргийн шалгаж, тогтоохгүй байгаа тул холбогдох газарт нь уламжилж өгнө үү. Яаралтай шалгаж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн албанаас гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар 15-4/1580 дугаар албан бичгээр иргэн С.Наранбаярт хариу мэдэгдсэн болно.
42	2021.06.10	0000058148	Энэ оны 04 дүгээр сарын 14-ний өдөр торгуулиа төлсөн боловч мэдээллийн сангаас хасагдаагүй байна. Жолооны үнэмлэхийн дугаар 530855, регистрийн дугаар РБ86092937 Торгууль төлсөн баримтыг хавсаргав.	Гомдол /веб хуудас/	Иргэний гомдлыг хүлээн авч, Тээврийн цагдаагийн албанаас "Торгууль.мн"сайтад торгуулийг засварлуулж, энэ тухай 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 88054147 дугаарын утсаар тантай холбогдож, хариу мэдэгдсэн байна.

43	2021.06.10	0000058044	Танил маань байр хямд үнээр авч өгнө гээд 2018 онд 25 сая төгрөг авсан юм. Тэгээд нэг байранд оруулаад байрны түлхүүр өгсөн. Тэр байранд нь амьдраад 2 жил болж байтал залилангийн хэрэгт холбогдсон болж, дахиад өөр хямдхан байр байна яг одоо 35 сая төгрөг олоод ир гэхээр нь хүнээс мөнгө аваад өгсөн. Гэтэл наадмын дараа байрны түлхүүрийг нь өгнө гээд өгөөгүй. Дахиад нэг квотын байр гарлаа гээд бас 35 сая төгрөг олоод өг гэхээр нь дүүгээсээ аваад өгсөн. Намайг биш дараа нь олон хүнийг залилсан юм байна. Гэтэл энэ хүн дахиад иргэдийг залилаад гадуур чөлөөтэй яваад байна. Шалгаж, иргэнд хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Мөрдөн байцаах албанаас шалгалтын ажиллагаа явуулж, 12/4-3716 дугаар албан бичгээр иргэн Н.Энхбаатард хариу мэдэгдсэн болно.
44	2021.06.21	0000063368	Миний бие дэлгүүр архи худалдаалахгүй байгаа талаар дуудлага өгсөн юм. Гэтэл Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн 1 дүгээр хэлтсийн цагдаа ирээд намайг гэртээ байхад зодсон. Хүнийг шалтгаангүй зодох эрх цагдаад байдаг юм уу? Холбогдох газраар шалгуулж, хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	БЗДЦГ-ын нэгдүгээр хэлтсийн 2021.07.07-ны өдрийн 26ш1-н/2924 албан бичгээр Иргэн Ч.Батжаргалд хариуг өгөв. /Албаны шалгалт явуулахад алба хаагчийн буруутай үйлдэл тогтоогдоогүй болохыг мэдэгдье/
45	2021.06.22	0000063993	Иргэдээс ирүүлсэн санал, гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэж, албан үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа Баянгол дүүрэг дэх цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа М.Батсайхан, 2 дугаар хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Н.Сумьяа, хэв журмын тасгийн дарга н.Хүрэл-Эрдэнэ нарт нь талархал илэрхийлж цаашдын ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
46	2021.06.22	0000063609	2017 оноос хойш хайж байсан төрсөн ах Т.Ууганбаярын сургийг гаргаж өгсөн Баянзүрх дүүрэг дэх цагдаагийн газрын 3-р хэлтсийн Бямбажав даргатай Эрүүгийн тасгийн алба хаагчдад талархал илэрхийлж, цаашдын ажилд нь өндөр амжилт хүсэн ерөөе. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
47	2021.06.23	0000060847	Цагдаагийн алба хаагчид байцаалтад будлиан оруулна, хохирогч гомдол гаргахад шалгаж өгөхгүй нуун дарагдуулж байна. Сонгинохайрхан дүүрэг дэх цагдаагийн газрын мөрдөн байцаах тасгийн дарга Жанчивдорж, ахлах мөрдөгч Мөнхжаргал болон бусад байцаагч нар хавтаст хэрэгтэй танилцахгүй, прокурорын байгууллагад худал мэдээлэл өгч байгаад гомдолтой байх тул холбогдох газарт нь уламжилж, хариу өгнө үү.	Гомдол /биечлэн/	Мөрдөн байцаах албанаас иргэнд хариу мэдэгдсэн болно.

48	2021.06.23	0000064151	Хөвсгөл аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Энхбаяр нь 6 сарын 17-наас 18-нд шилжих шөнө ойн мэргэжлийн байгууллагын талбай дээр зөрчил гарлаа гээд манай нөхөртэй хөдөө албан ажлаар явсан юм. Шалгасан байгууллагаасаа архи авч уугаад буцах замдаа жолоочтойгоо нийлж доод албан тушаалтныгаа зодсон. Шөнө зодуулаад ирэхээр нь эмнэлэгт үзүүлэхэд тархины хүнд хэлбэрийн доргилт гэсэн оноштой хэвтэн эмчлүүлж байна. Энэ талаар цагдаагийн байгууллага болон аймгийн Засаг даргад гомдол гаргахад шалгаж, шийдэж өгөхгүй байна. Холбогдох газарт нь уламжилж, иргэнд яаралтай хариу өгнө үү.	Гомдол /дуудлага/	Хөвсгөл аймаг дахь цагдаагийн газраас иргэнд хариу мэдэгдсэн болно.
49	2021.07.08	000068947	Танай цахим хуудсаар дамжуулан 6 сарын 8нд гомдол гаргасан боловч одоог хүртэл шийдвэрлэгдсэнгүй. Өргөдөл гомдлын тухай хуульд өргөдөл, гомдлыг 30 хоногт багтаан шийдвэрлэнэ гэсэн байдаг. Энэ хугацаа өнгөчихлөө!!! 30 хоног байтугай богино хугацаанд шийдвэрлэх боломжтой асуудлыг яагаад ийм удаан хугацаанд шийдвэрлэдэг юм бэ? Яагаад шийдвэрлэлтэд нь хяналт тавьдаггүй юм бэ? Өмнө гаргасан хүсэлтийн дугаар 000058148	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Тээврийн цагдаагийн албанаас \\\"Торгууль.мн\\\"сайтад торгуулийг засварлуулж, энэ тухай 2021 оны 06 дугаар сарын 14-ний өдөр 88054147 дугаарын утсаар тантай холбогдож, хариу мэдэгдсэн байна.
50	2021.07.23	0000071371	2019 онд Хэнтий аймгийн Цагдаагийн газарт хүн эрэн сурвалжлуулахаар хандсан боловч өнөөдрийг хүртэл эрэн сурвалжлах ажиллагааг бүрэн гүйцэтгэлгүй хүнд суртал үзүүлж байна. Холбогдох байгууллагад нь уламжилж, арга хэмжээ авч өгнө үү.	Гомдол /дуудлага/	Эрүүгийн цагдаагийн албанд шалгалтын ажиллагаа явуулж, иргэнд хариу мэдэгдсэн болно.
51	2021.07.23	0000069037	6 сарын 8-нд гаргасан 58148 дугаартай гомдлыг өнөөдөр хааж байна. Гэхдээ шийдвэрлээгүй байж шийдвэрлэсэн гэж, утасаар холбогдоогүй байж холбогдсон гэж... \n6 сарын 8-ны гомдол шийдвэрлэгдээгүй 30 хоносон тул дахин 7 сарын 8-нд 68947 дугаартай гомдол гаргасан. Энэ гомдлыг мөн л өнөөдөр буюу 7сарын 9-нд хааж байна. Бас л шийдвэрлээгүй байж шийдвэрлэсэн гэж, утасаар холбогдоогүй байж холбогдсон гэж... гэхдээ хаасан тайлбар дээрээ 6 сарын 14-д холбогдож мэдэгдсэн гэж худалаа тайлбартай байна.\nШийдвэрлэгдсэн гээд байгаа гомдлын шийдвэрлэлтийг бодит зурагаар оруулав.\n1. Өргөдөл гомдлын тухай хуульд заасны дагуу өргөдөлийг	Гомдол /дуудлага/	Иргэн Ч.Энхбатын гаргасан гомдлын дагуу Тээврийн цагдаагийн албанаас 2021.07.27-ны өдөр 88054147 дугаарын утсаар холбогдож, торгуулийн талаарх мэдээллийг дахин авч, 530855 дугаартай жолооны үнэмлэх дээрх торгууль төлөлтийн мэдээллийг засварлаж, дутуу байсан 310000618073103 дугаартай торгууль төлсөн баримтыг torguul.police.gov.mn хаягаар хүлээн авч, шийдвэрлэсэн бөгөөд иргэн торгууль төлөхдөө торгуулийн хуудасны дугаар дээр автомашины дугаар, регистрийн

			яагаад 30 хоногт багтаан шийдвэрлэсэнгүй вэ?\n2. Шийдвэрлээгүй байж шийдвэрлэсэн гэж яагаад худал хариу өгөв өө?\n3. Энэ удаан хугацаанд иргэнийг чирэгдүүлсэн үйлдэлд хэн хариуцлага хүлээх вэ?		дугаар, нэр гэх мэт нэмэлт мэдээллийг бичсэн тул засагдаагүй байсан талаар тайлбарласан болно.
52	2021.07.23	0000073765	1111-4. 2021.06.23-ны өдөр зөрчил гаргаж 400 мянган төгрөгөөр торгуулж, торгуулиа тэр даруй төлсөн юм. Гэвч e-mongolia системд одоо хүртэл торгуулиа төлөөгүй байна гэсэн мэдээлэлтэй байна. Хасалт хийх 70191319 дугаар огт утсаа авдаггүй. Иймд энэхүү асуудлыг холбогдох байгуулагад уламжлан шийдвэрлэж өгнө үү.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлын дагуу Тээврийн цагдаагийн албанаас торгуулийн төлөлтийг Төрийн сангийн данснаас шүүхэд гарч ирээгүй, торгуулийн дансны дугаарыг андуурч шилжүүлсэн байх тул төлсөн баримтын хуулбарыг \"torguuli.mn@gmail.com\" хаягаар хүлээн авч засварлуулсан. Иргэнд энэ талаар хариу мэдэгдсэн болно.
53	2021.07.30	0000073780	70191319 утас ерөөсөө утсаа авахгүй байна хасалт хийлгэх гэсэн юм. Холбогдох газарт нь уламжилж өгнө үү.	Гомдол /дуудлага/	Иргэний гомдлыг хүлээн авч, Тээврийн цагдаагийн албанаас 80487828 дугаарын утсаар иргэн Д.Билгүүдэйтэй холбогдож, Өршөөлийн тухай хуулийн дагуу эрх сэргээгдсэн иргэд хандаад утасны дугаар ачаалал ихтэй байсан талаар мэдээлэл өгсөн. Д.Билгүүдэй нь торгуультай холбоотой асуудлаа шийдвэрлүүлсэн, гомдол саналгүй гэсэн болно.
54	2021.08.04	000075560	2021 оны 8 дугаар сарын 4-ний өдөр 102 дуудлагаар ирсэн Хан-уул дүүргийн цагдаагийн газрын 1-р хэлтэс, арцатын 118 дүгээр чиглэл хариуцсан дэслэгч П.Мөнхсайхан, сургагч ахлагч Л.Мягмарсүрэн нар маршал таунд гар утсаа алдаад байж байхад түргэн шуурхай олж өглөө. Баярлалаа.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
55	2021.08.09	0000076939	Баянзүрх дүүргийн цагдаагийн 2-р хэлтсийн эргүүлийн офицер Д.Золбаяр, эргүүлийн цагдаагийн жолооч Т.Гантогтох нарт манай хүүхдийг 20 орчим хоног алга болсон байхад олж өгсөнд маш их баярлалаа. Цаашдын ажилд нь амжилт хүсье.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
56	2021.08.10	0000077527	Чингэлтэй дүүргийн 19-р хорооны дэслэгч цолтой Амгаланбаатар гэж цагдаа байгаа. Энэ хүнийг сайн ажиллаж байна гэж талархал илэрхийлэх гэсэн юм. Хүний төлөө, идэвхтэй, сайн залуу байна. Баярлалаа. Ажилд нь амжилт хүсье.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.

57	2021.08.23	000082414	Халаасны гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн цагдаа Лхамд миний утсыг олж өгсөнд баярлалаа гэдгээ хэлмээр байна. Ажилд нь амжилт хүсье.	Талархал /дуудлага/	Талархлыг алба хаагчдад хүргэж, ажлын амжилт хүсэв.
----	------------	-----------	---	---------------------	---